



ХӨГЖМИЙН ТОМ ХЭЛБЭРИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ УЛСЫН САНД ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мэргэжлийн хөгжмийн урлагийн хөгжлийг дэмжих зорилгоор Монголын хөгжмийн зохиолчдын бүтээсэн хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийг сонгон шалгаруулах, үнэлэх, улсын санд худалдан авах, бүртгэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Соёлын тухай хууль, Төрөөс баримтлах Соёлын бодлого, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Төрөөс Соёлын талаар баримтлах бодлого, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Архивын тухай хууль, болон бусад холбогдох хууль, эрхзүйн баримт бичгийг баримтална.

1.3. Хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээл (цаашид "бүтээл" гэх)-ийг шалгаруулж, улсын санд худалдан авснаар дараах зорилгыг хангана. Үүнд:

- мэргэжлийн урлагийн болон сургалтын байгууллагын урын санг баяжуулах,
- хөгжмийн зохиолчдыг хөхиүлэн дэмжих,

- бүтээлийг уран бүтээл, сургалт, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулах,
- хөгжмийн урлагийн шүүмж, судлалыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн алтан сан хөмрөгт дуу, дүрсний стандартын дагуу хадгалуулах,
- хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан таниулах боломж бий болгох,
- Монгол Улсын хөгжмийн бүтээлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болгоход тус тус оршино.

1.4. Бүтээлийг худалдан авсан мөнгөн урамшууллыг дагалдуулан шилдэг бүтээлийн батламж олгож болно.

Хоёр. Бүтээлд тавигдах шаардлага

2.1. Хөгжмийг зохиолч нь мэргэжлийн хөгжмийн урлагийн дэвшил ололтыг агуулсан, шинэ агуулга бүтээмжийг эрэлхийлсэн, уран бүтээлчдийн ур чадварыг илтгэн харуулах, үнэ цэнтэй соёлын өв болохуйц, сүүлийн 3 жилд туурвисан уг журмын 2.1.1- заасан шаардлагыг хангасан 2.1.2, 2.1.3, 2.1.4 -т заасан бүтээлийг ирүүлнэ. Энэхүү журамд дараах бүтээл, агуулгыг хамруулан ойлгоно.

- 2.1.1 “Хөгжмийн том хэлбэрийн бүтээл”-тухайн бүтээлийн сонгодог болон орчин үеийн хэлбэрийг /форм/ баримтлан, тухайн төрлийнхөө илэрхийлэмжийг гаргаж, найрал хөгжмийн зэмсэгжүүлэлт найруулгыг мэргэжлийн түвшинд бичсэн хөгжмийн бүтээлийг;
- 2.1.2 “Тайзны том хэлбэрийн бүтээл” -дуурийн хөгжим, бүжгэн жүжгийн хөгжим, дуулалт /мюзикл/ болон хөгжимт жүжгийн хөгжим;
- 2.1.3 “Дан хөгжим болон дуулаачийн том хэлбэрийн бүтээл”-симфони сюит, найраглал, удиртгал, уран сэтгэмж, ялгуусан дуулал, магтуу;
- 2.1.4 “Гоцлол хөгжмийн том хэлбэрийн бүтээл” - концерт, концертино, сонат;
- 2.1.5 “Зохиогч”- тухайн бүтээлийг Оюуны өмчийн хуулийн дагуу эзэмших эрх бүхий байгууллага, хувь хүн болон мэргэжлийн уран бүтээлч;
- 2.1.6 “Мэргэжлийн зөвлөл” -соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон төлөөлөл;
- 2.1.7 “Шилдэг бүтээл”- тухайн жилд улсын санд худалдан авсан бүтээлийг;

2.2. Зохиогч нь бүтээлээ соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараах баримт бичгийн бүрдүүлж, тухайн оны 09 дүгээр сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ:

- 2.2.1.Улсын санд бүтээлээ худалдах тухай хүсэлт, өргөдөл;
- 2.2.2 Бүтээлийн тухай товч танилцуулга, бүтээлийн үнэлгээ;
- 2.2.3.Мэргэжлийн урлагийн байгууллагын уран сайхны зөвлөлийн санал, дүгнэлт
- 2.2.4.Зохиогчийн эрхийг баталгаажуулсан баримт бичгийн хуулбар;

2.2.5. Бүтээлийн дарамж /клавир/, удирдвар /партитур/-ын эх хувь бичвэрийг мэргэжлийн түвшинд хийгдсэн дижитал хувилбарын хамт тус тус ирүүлнэ.

2.2.6. Бичиг баримтын бүрдэл дутуу тохиолдолд болон хугацаа хоцорсон бүтээл нь сонгон шалгаруулалтын бүртгэлд хамрагдах боломжгүй болно.

Гурав. Шилдэг бүтээлийг сонгон шалгаруулж, худалдан авах

3.1. Шилдэг бүтээлийг сонгон шалгаруулах орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид “зөвлөл” гэнэ)-ийн бүрэлдэхүүнийг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, зөвлөлийн ажиллах журмыг батална.

3.2. Шилдэг бүтээлийн сонгон шалгаруулалтыг 3 үе шаттай зохион байгуулна.

3.2.1. нэгдүгээр шатанд ирүүлсэн нийт бүтээлийг мэргэжлийн урлагийн байгууллагын санал дүгнэлтэд үндэслэн журмын 2.1-т заасан шаардлагын дагуу ирүүлсэн удирдвар болон бичлэгийг сонсож сонгон шалгаруулна.

3.2.2. эхний шатанд тэнцсэн бүтээлд зориулсан хөгжмийн шүүмж судлалын улсын уралдааныг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулж, шилдэг шүүмж судлалыг шалгаруулж, бүтээлийн хамт дараагийн шатанд нэр дэвшүүлнэ.

3.2.3. хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад нэр дэвшсэн нийт бүтээлийг “Алтан намар” мэргэжлийн хөгжмийн наадамд оролцуулж, шилдэг бүтээлийг сонгон шалгаруулна.

3.3. Шалгарсан бүтээлийг улсын санд худалдан авахдаа зөвлөлийн гаргасан санал дүгнэлтэд үндэслэн зохиогчийн үнэлсэн үнэлгээнд тулгуурлан уг журмын хавсралтаар баталсан жишиг үнэтэй дүйцүүлэн, зохиогчтой харилцан тохирч үнэлнэ.

Дөрөв. Шилдэг бүтээлийг худалдан хөрөнгө, түүний зарцуулалт

4.1. Улсын санд худалдан авахаар шийдвэрлэсэн шилдэг бүтээлийг тухайн жилд хуваарилсан хөрөнгөд багтаан улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Хөгжмийн бүтээл худалдан авах тухай соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр нь хөрөнгийг захиран зарцуулах үндэслэл болно.

4.3. Төсвөөс олгосон хөрөнгийн 15 хувийг шилдэг бүтээлийг цахим хэлбэрт оруулах, сурталчлах, зөвлөлийн гишүүд болон шүүмж, судлаачдад урамшуулал олгоход зарцуулна.

4.4. Энэ журмын биелэлтэд соёлын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргаааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

Тав. Шилдэг бүтээлийн улсын сангийн бүртгэл, хадгалалт хамгаалалт

5.1. Улсын санд худалдан авсан шилдэг бүтээлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага бүрдүүлж, цахим хэлбэрээр хадгалан хэрэглэгчдийн хүртээл болгоно.

5.2. Шилдэг бүтээлд нэр дэвшсэн болон шалгарсан бүтээлийн бичвэр, түүний дагалдах баримт бичиг болон зөвлөлийн хурлын тэмдэглэл, санал дүгнэлт, холбогдох тушаал шийдвэрийг флаш дискэнд хуулбарласан дижитал бичвэрийн хамт Улсын архивт шилжүүлэн хадгалуулна.

5.3. Худалдан авсан бүтээлийн дарамж /клавир/, удирдвар /партитур/-ын эх хувь бичвэрийг улсын улсын санд хадгалж, хуулбар хувийг мэргэжлийн урлагийн болон сургалтын байгууллага энэхүү журмын 6.2-т заасны дагуу ашиглахад зориулан урын санд бүртгэн хадгална.

5.4. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүрдүүлсэн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн бүртгэл, хадгалалт хамгаалалтад холбогдох журмын дагуу жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, үр дүнг тооцон Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

Зургаа. Бүтээлийн зохиогчийн эрх, ашиглалт

6.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүтээлээ худалдсан зохиогчтой харилцан тохиролцсоны дагуу бүтээлийн онцгой эрх шилжүүлэх тухай гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 10 жилийн хугацаатай байгуулна.

6.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын санд худалдан авсан шилдэг бүтээлийг дараах арга хэлбэрээр шууд ашиглана. Үүнд:

6.2.1. мэргэжлийн урлагийн байгууллагууд шилдэг бүтээлүүдээр жилд 3-аас доошгүй удаа тоглолт зохион байгуулах;

6.2.2 мэргэжлийн сургалтын байгууллагууд шилдэг бүтээлүүдийг сурах бичиг, сургалтын хөтөлбөрт тусгах,

6.2.3 шилдэг бүтээлийг төрийн өмнөөс зохион байгуулах соёлын өдөр, түүхэн тэмдэглэлт ойн баяр наадам болон бусад хүндэтгэлийн тоглолтын хөтөлбөрт тусган нийтийн хүртээл болгох,

6.2.4 олон улсын чанартай уралдаан тэмцээнд удирдварыг илгээн оролцуулах, монгол улсыг гадаад, дотоодод сурталчлах арга хэмжээнд тоглуулах,

6.2.5 нийгмийн сэтгэл санааг дэмжих, эдийн засгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулж буй үйл ажиллагаа, арга хэмжээнд улсын санд худалдан авсан шилдэг бүтээлийг шууд ашиглана.

6.2.6 Монголын үндэсний радио нь улсын сан дахь шилдэг бүтээлийг энэ журмын 1.2-т заасны дагуу хөгжмийн зохиолын удирдвар дахь хөгжмийн хувь /парт/ тус бүрээр нарийвчлан бичиж, өргөн нэвтрүүлгийн сувгаар сурталчлан нэвтрүүлнэ.

6.3. Улсын санд худалдан авсан Шилдэг бүтээлийн гэрээний хүчин төгөлдөр хугацаанд шилдэг бүтээлийг соёлын үүсмэл бүтээл болгон ашиглах, бүтээгдэхүүн

болгон үйлдвэрлэх, шинэ уран бүтээл болгон гаргах тохиолдолд зохиогчийн гаргасан хүсэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний зөвшөөрөл олгосны үндсэн дээр сонирхогч этгээдтэй гэрээ байгуулан ашиглуулж болно.

6.4. Зохиогч нь гэрээний хүчин төгөлдөр хугацаанд улсын санд худалдан авсан шилдэг бүтээлийг бусдад журмын 6.3-т зааснаас өөр хэлбэрээр бусдад зөвшөөрөлгүйгээр ашиглуулах, давхар худалдахыг хориглоно.

6.5. Мэргэжлийн урлагийн болон мэргэжлийн сургалтын байгууллага нь улсын санд худалдан авсан шилдэг бүтээлийг тухайн жилд ашиглаж, сурталчлан таниулсан үйл ажиллагааны тайланг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.


----oOo---

Хөгжмийн том хэлбэрийн, шилдэг
бүтээлийг улсын санд худалдан авах,
бүртгэх журмын хавсралт

**Хөгжмийн том хэлбэрийн төрөл,
түүний нэг бүрийн жишиг үнэлгээний хүснэгт**

№	Бүтээлийн хэлбэр	Бүтээлийн төрөл	Үнэлгээ /сая.төг/
1	Хөгжмийн театрын том хэлбэрийн бүтээл	Дуурь,	40,0 - 50,0 хүртэл
2		Дуулалт болон хөгжимт жүжиг /Мюзикл/	30,0- 40,0 хүртэл
3		Балет	40,0 - 50,0 хүртэл
4		Бүжгэн жүжиг	30,0- 40,0 хүртэл
5	Дан хөгжмийн том хэлбэрийн бүтээл	Симфони /1-4 ангит/, Симфони сюит, Симфони уран сэтгэмж, Симфони найраглал	10,0 - 30,0 хүртэл
6		Сонат, Концерт, Концертино, Удиртгал, Найраглал, Уран сэтгэмж, Ялгуусан дуулал /Оратори/ Магтуу /Контат/	10,0 - 25,0 хүртэл

----oOo----



ТӨСӨЛ

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ УЛСЫН САН ХӨМРӨГТ ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг сонгон шалгаруулах, үнэлэх, улсын сан хөмрөгт худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Мэргэжлийн зөвлөл нь дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг сонгон шалгаруулахдаа төрөөс дүрслэх урлагийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг дэмжих зарчим баримтална.
- 1.3. Энэхүү журмыг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон зохих эрх зүйн актуудыг удирдлага болгон дагаж мөрдөнө.
- 1.4. Дараах дүрслэх урлагийн бүтээлүүдийг шилдэг, үнэт бүтээлд хамааруулна:
 - 1.4.1 Уран зураг;
 - 1.4.2 Уран баримал;
 - 1.4.3 Монгол зураг;

- 1.4.4 Зураасан зураг;
- 1.4.5 Чимэглэх урлаг;
- 1.4.6 Орчин үеийн урлаг/ Контемпорари урлаг/

Хоёр. Журманд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт

2.1. Нэр томъёог дараах утгаар ойлгоно:

2.1.1. “Дүрслэх урлагийн шилдэг бүтээл” гэж дүрслэх урлагийн хөгжлийн ололт, чиг хандлага, үзэл баримтлалыг илэрхийлсэн, сэдэв, агуулга, арга ажиллагааны хувьд өвөрмөц, дахин давтагдашгүй, мэргэжлийн өндөр түвшинд төгс гүйцэтгэсэн, шинэ санаа агуулгатай энэ журмын 1.4-т заасан бүтээлийг хэлнэ.

2.1.2. “Улсын сан хөмрөг” гэж Монголын Уран зургийн галерейд хадгалагдаж буй дүрслэх урлагийн шилдэг бүтээл, түүний хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн орон зайг хэлнэ.

2.1.3. “Мэргэжлийн зөвлөл” гэж тухай бүр соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаал, шийдвэрээр батлагдсан орон тооны бус ажлын хэсгийг хэлнэ.

2.1.4. “Мэргэжлийн уран бүтээлч” гэж дүрслэх урлагийн төрлөөр суралцаж мэргэжлийн үнэмлэхтэй, дүрслэх урлагийн чиглэлээр уран бүтээл туурвиж мэргэшсэн уран бүтээлчийг хэлнэ.

Гурав.Мэргэжлийн зөвлөлийн бүтэц, эрх үүрэг

3.1. Мэргэжлийн зөвлөл нь энэ журмын 1.3-т заасан хууль, эрх зүйн актуудыг удирдлага болгон энэ журмын 1.4-т заасан бүтээлүүдийг уран бүтээлч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өв залгамжлагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр Улсын сан хөмрөгт худалдан авах, эс авах тухай дүгнэлт гаргаж тухай бүр соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

3.2. Мэргэжлийн зөвлөл нь 7 гишүүнтэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

3.3. Зөвлөлийн даргыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилно.

3.4. Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд:

3.2.1. Зөвлөлийн дарга нь тухай бүр соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл,

3.4.1. Монголын Уран зургийн галерейн төлөөлөл,

3.4.2. Соёлын өвийн үндэсний төвийн шинжээч, сэргээн засварлагч-судлаачдын төлөөлөл,

3.4.3. Монголын урчуудын эвлэлийн төлөөлөл,

3.4.4. Мэргэжлийн сургуулийн төлөөлөл,

3.4.5. Урлаг судлаач, шүүмжлэгч, кураторын төлөөлөл,

3.4.6. Мэргэжлийн уран бүтээлчдийн төлөөлөл тус тус байна.

3.5. Мэргэжлийн зөвлөл нь дүрслэх урлагийн шилдэг бүтээлийн сонгон шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулна. Эхний шатанд оролцуулах бүтээл, холбогдох мэдээллийг цахимаар хүлээн авч шалгаруулалтыг хийх ба шалгарсан бүтээлүүд нь “Оны шилдэг бүтээлийн үзэсгэлэн”-д оролцох эрх үүснэ.

3.6. Мэргэжлийн зөвлөл нь 85% хувиас доошгүй ирцтэй хуралдаж, бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авах, эсэх шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар гаргана.

3.7. Мэргэжлийн зөвлөлийн хурлаас тэмдэглэл, дүгнэлт гарах бөгөөд ажлын хэсгийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.8. Хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэж тухай бүр соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тушаал, шийдвэр гаргаснаар дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авах эрх үүснэ.

3.9. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хурлын товыг зарлах, хэлэлцэх асуудлын хүрээнд нэр дэвшсэн уран бүтээлийн жагсаалтыг боловсруулан гишүүдэд танилцуулах, тараах, ажлын уялдааг хангах, хурлын тэмдэглэлийг үнэн зөв хөтлөх, холбогдох материалуудын бүрэн гүйцэд байдлыг хангана.

3.10. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом, зэрэг, цолыг тодорхойлох баримт бичгийн хуулбаруудыг авч хурлын тэмдэглэл, дүгнэлтэд хавсаргана.

3.11. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн тушаал шийдвэр, хурлын тэмдэглэл, хавсралт, шинжээчийн дүгнэлт, “Уран бүтээл худалдах, худалдан авах, онцгой эрх шилжүүлэх тухай” гэрээ /Хавсралт/ зэрэг холбогдох бичиг баримтын иж бүрдлийг бүрдүүлнэ. Иж бүрдлийг 2 хувь бэлтгэн 1 хувийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, 1 хувийг тус журмыг хэрэгжүүлэгч байгууллагын архивд тус тус хүлээлгэн өгнө.

Дөрөв. Бүтээлд тавигдах шаардлага

4.1. Улсын сан хөмрөгт 1.4-т заасан төрлийн 2.1.1-т заасан бүтээлийг худалдан авна.

4.2. Дүрслэх урлагийн шилдэг бүтээл нь материал технологийн хувьд чанартай хийгдсэн, тэсрэх дэлбэрэх аюулгүй, хими физикийн урвалд орохгүй, мал амьтны түүхий эдийг дээд зэргээр боловсруулсан, цаг хугацааны шалгуур даах, галерейн сан хөмрөгийн стандартад нийцсэн, хадгалах, зөөвөрлөх, нийтэд дэлгэн үзүүлэх боломжтой бүтээгдсэн байна.

4.3. Улсын сан хөмрөгт бүтээлээ худалдсан уран бүтээлч нь уг бүтээлээ дахин хувилах, олшруулах, хэсэгчлэн ашиглахыг хориглоно.

4.4. Улсын сан хөмрөгт бүтээлээ худалдсан уран бүтээлч нь энэ журмын 4.3-г зөрчсөн, мөн бүтээн туурвих явцаас шалтгаалан хадгалалтын явцад шинжээчийн дүгнэлтээс өөр байдлаар эрс хувирсан зэрэг шалгаруулалтад сонгогдсон үеийн шинж байдлаасаа өөрчлөлт орсон бол гэрээг цуцалж төлбөрийг буцаах бөгөөд уран бүтээлээ эргүүлэн өөртөө авна.

- 4.5. Дүрслэх урлагийн шилдэг бүтээл нь дотоод, гадаадын олон улсын үзэсгэлэнд оролцсон болон шагнал хүртсэн бол гэрчлэх бичиг баримтыг хавсаргасан байна.
- 4.6. Дүрслэх урлагийн шилдэг бүтээл нь уран бүтээлчийн сүүлийн 3 жилд туурвисан бүтээл байна.
- 4.7. Шаардлагатай, онцгой тохиолдолд мэргэжлийн зөвлөлөөс гаргасан саналыг үндэслэн он харгалзахгүйгээр бүтээгдсэн бүтээлийг худалдан авч болно.

Тав. Бүтээлийг худалдан авах хөрөнгө, түүний зарцуулалт

- 5.1. Улсын төсвөөс улсын сан хөмрөгт худалдан авахаар сонгосон бүтээлийг тухайн жилд хуваарилсан төсөвт багтаан санхүүжүүлнэ.
- 5.2. Төсвөөс олгосон хөрөнгийн 85% хувийг дүрслэх урлагийн шилдэг бүтээлд, 15% хувийг бүтээл сурталчлах, үзэсгэлэн зохион байгуулах, урлагийн зөвлөлийн гишүүдийн урамшуулал болон бусад үйл ажиллагааны зардалд зарцуулна.
- 5.3. Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг худалдан авах тухай соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр нь хөрөнгийг захиран зарцуулах үндэслэл болно.
- 5.4. Улсын сан хөмрөгт худалдан авсан дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг Музейн тухай хуулийн 12 дугаар зүйл, холбогдох журмын дагуу Монголын Уран зургийн галерейн сан хөмрөгт бүртгэн авна.
- 5.5. Монголын Уран Зургийн галерей нь Улсын сан хөмрөгт тухайн жилд худалдан авсан шилдэг бүтээлийн ерөнхий бүртгэл, сурталчилгаа, судалгаа, сургалтад ашигласан эсэх тухай холбогдох мэдээ тайланг Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил тутамд тайлагнана.
- 5.6. Энэхүү журмын биелэлтэд санхүүгийн болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

Зургаа. Бүтээлийн зохиогчийн эрх

- 6.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүтээлээ худалдсан уран бүтээлч иргэн, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өв залгамжлагчтай энэ журмын 1.3-т заасан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээг байгуулна.

----oOo----